

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Байгаль орчны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2026/75/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дундговь аймаг 2026 он	Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn Аудитын менежер: Т.Батсайхан Утас: 70592225 Цахим хаяг: Batsaikhant@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Угтахбаяр Утас: 70593113 Цахим хаяг: Ugtakhbayarj@audit.gov.mn Аудитор: Б.Сарангуа Утас: 70593113 Цахим хаяг: Saranguab@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	
/төгрөгөөр/.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	
/төгрөгөөр/.....	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	
/төгрөгөөр/.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	
/төгрөгөөр/.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	9
5.1 Төлбөрийн акт	9
5.2 Албан шаардлага.....	9
5.3 Зөвлөмж.....	10
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цэцэм хаяг: dundgovi@audit.gov.mn

2026.04.25 № 51

тасай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Байгаль орчны газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Байгаль орчны газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад төсвөөс олгох санхүүжилтийг 345.8 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь өмнөх оноос цалин хөлс болон нэмэгдэл урамшил, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, зардлууд өссөнтэй холбоотой байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал байхгүй. Харин тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ нь элэгдлээ бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй хөрөнгийг дахин үнэлж, орлого авсан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй

4826050175

болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 15 зорилтын 68 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, сумын Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 98.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,617,535.00	14,835.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	3,617,535.00	14,835.00
3121	Төгрөг	3,617,535.00	14,835.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	3,617,535.00	14,835.00
33	АВЛАГА		169,766,091.00
331	Ажиллагчидтай холбогдсон авлага		91,175.00
335	Бусад авлага		169,674,916.00
3351	Байгууллагаас авах авлага		169,674,916.00
35	БАРАА МАТЕРИАЛ	23,004,197.98	25,444,397.98
354	Хангамжийн материал	23,004,197.98	25,444,397.98
3541	Бичиг хэргийн материал	1,158,700.00	978,850.00
3542	Аж ахуйн материал	16,087,297.98	15,561,347.98
3543	Сэлбэг хэрэгсэл	2,821,500.00	4,201,500.00
3544	Түлш, шатах тослох материал	1,130,000.00	830,000.00
3545	Барилгын засварын материал	1,806,700.00	3,872,700.00
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	26,621,732.98	195,225,323.98
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	443,744,618.06	460,364,647.76
392	Биет хөрөнгө	429,103,084.78	446,037,714.52
39201	Барилга, байгууламж, орон сууц	330,118,735.66	330,118,735.66
39202	Хуримтлагдсан элэгдэл	(41,593,933.03)	(48,479,958.91)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	61,220,344.00	45,135,837.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(31,614,646.93)	(10,029,625.93)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	111,953,563.00	130,884,653.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(45,970,507.99)	(44,759,080.92)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	71,071,382.00	72,891,814.04
39208	Хуримтлагдсан элэгдэл	(27,984,351.93)	(31,627,159.42)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,902,500.00	1,902,500.00
393	Биет бус хөрөнгө	14,641,533.28	14,326,933.24
39301	Програм хангамж	1,573,000.00	1,573,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(419,466.72)	(734,066.76)
39303	Бусад биет бус хөрөнгө	13,488,000.00	13,488,000.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	443,744,618.06	460,364,647.76
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	470,366,351.04	655,589,971.74
51	Засгийн газрын хувь оролцоо	470,366,351.04	655,589,971.74
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	389,700,520.28	389,700,520.28
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	389,700,520.28	389,700,520.28
512	Хуримтлагдсан үр дүн	17,014,533.45	202,238,154.15
5121	Өмнөх үеийн үр дүн	17,014,533.45	17,014,533.45
5122	Тайлант үеийн үр дүн		185,223,620.70
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	63,651,297.31	63,651,297.31
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	470,366,351.04	655,589,971.74
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	470,366,351.04	655,589,971.74

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	973,811,558.00	1,319,643,967.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	148,206,858.00	291,256,367.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	118,979,858.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	29,227,000.00	291,256,367.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	825,604,700.00	1,028,387,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	825,604,700.00	1,028,387,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,502,500.00	65,579,404.48

120	Нийтлэг татварын бус орлого	2,502,500.00	65,579,404.48
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	300,000.00	400,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	300,000.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		400,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,902,500.00	59,453,404.48
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	300,000.00	5,726,000.00
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	976,314,058.00	1,385,223,371.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	991,929,257.15	1,199,999,750.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	787,680,709.51	1,113,019,593.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	579,994,384.00	772,754,268.00
210101	Үндсэн цалин	340,529,701.00	417,531,921.00
210102	Нэмэгдэл	168,061,626.00	254,900,765.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,104,000.00	40,289,294.00
210104	Урамшуулал	48,299,057.00	60,032,288.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	71,795,454.10	95,390,484.39
210201	Тэтгэврийн даатгал	49,240,571.07	65,038,502.75
210202	Тэтгэмжийн даатгал	5,821,626.38	7,868,476.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,867,913.28	3,862,958.45
210204	Ажилгүйдлийн даатгал	2,768,615.03	3,724,109.51
210205	Эрүүл мэндийн даатгал	11,096,728.34	14,896,437.13
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,887,966.26	30,426,156.54
210301	Гэрэл, цахилгаан	2,099,942.26	2,604,015.07
210302	Түлш, халаалт	25,862,144.00	25,862,144.00
210303	Цэвэр, бохир ус	1,925,880.00	1,959,997.47
2104	Хангамж, бараа материалын зардал	19,027,970.00	27,094,055.00
210401	Бичиг хэрэг	1,676,500.00	1,382,250.00
210402	Тээвэр, шатахуун	11,905,200.00	13,908,360.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,536,380.00	2,556,185.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		36,860.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	420,790.00	6,006,190.00
210408	Бараа материал акталсны зардал	2,489,100.00	3,204,210.00
2105	Нормативт зардал		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,509,300.00	4,549,700.00
210604	Урсгал засвар	15,509,300.00	4,549,700.00
2107	Томилолт, зочны зардал	17,712,000.00	10,480,000.00
210702	Дотоод албан томилолт	17,712,000.00	10,480,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,650,562.00	10,806,562.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	200,000.00	7,550,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,500,000.00	1,800,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	114,192.00	114,192.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,724,000.00	1,230,000.00
210807	Газрын төлбөр	90,370.00	90,370.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,103,073.15	161,518,367.78
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,909,700.00	112,837,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	309,000.00	4,349,293.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	44,884,373.15	44,331,374.78
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	204,248,547.64	86,980,157.07
2132	Бусад урсгал шилжүүлэг	89,670,500.02	20,187,450.02
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	77,211,500.02	8,324,500.02
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,459,000.00	11,862,950.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	114,578,047.62	66,792,707.05
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,345,880.62	66,792,707.05
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	113,232,167.00	

II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	991,929,257.15	1,199,999,750.78
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(15,615,199.15)	185,223,620.70
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	56,333.36	
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	56,333.36	
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(56,333.36)	
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(15,671,532.51)	185,223,620.70

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	974,111,558.00	1,320,043,967.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	300,000.00	400,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	300,000.00	400,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	300,000.00	400,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	300,000.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		400,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	973,811,558.00	1,319,643,967.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	148,206,858.00	291,256,367.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	118,979,858.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	29,227,000.00	291,256,367.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	825,604,700.00	1,028,387,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	825,604,700.00	1,028,387,600.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	956,021,258.00	1,152,473,751.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	956,021,258.00	1,152,473,751.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	751,772,710.36	1,065,493,593.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	579,994,384.00	772,754,268.00
210101	Үндсэн цалин	340,529,701.00	417,531,921.00
210102	Нэмэгдэл	168,061,626.00	254,900,765.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,104,000.00	40,289,294.00
210104	Урамшуулал	48,299,057.00	60,032,288.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	71,795,454.10	95,481,659.39
210201	Тэтгэврийн даатгал	49,240,571.07	65,129,677.75
210202	Тэтгэмжийн даатгал	5,821,626.38	7,868,476.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,867,913.28	3,862,958.45
210204	Ажилгүйдлийн даатгал	2,768,615.03	3,724,109.51
210205	Эрүүл мэндийн даатгал	11,096,728.34	14,896,437.13
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,524,830.26	30,426,156.54
210301	Гэрэл, цахилгаан	2,099,942.26	2,604,015.07
210302	Түлш, халаалт	29,499,008.00	25,862,144.00
210303	Цэвэр, бохир ус	1,925,880.00	1,959,997.47
2104	Хангамж, бараа материалын зардал	19,992,280.00	20,362,255.00
210401	Бичиг хэрэг	1,350,200.00	1,208,300.00
210402	Тээвэр, шатахуун	13,035,200.00	13,608,360.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,536,380.00	2,556,185.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		36,860.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,070,500.00	2,952,550.00
2105	Нормативт зардал		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,884,500.00	7,995,700.00
210604	Урсгал засвар	19,884,500.00	7,995,700.00
2107	Томилолт, зочны зардал	17,712,000.00	10,480,000.00
210702	Дотоод албан томилолт	17,712,000.00	10,480,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,650,562.00	10,806,562.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	200,000.00	7,550,000.00

210803	Даатгалын үйлчилгээ	1,500,000.00	1,800,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	114,192.00	114,192.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,724,000.00	1,230,000.00
210807	Газрын төлбөр	90,370.00	90,370.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,218,700.00	117,186,993.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,909,700.00	112,837,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	309,000.00	4,349,293.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	204,248,547.64	86,980,157.07
2132	Бусад урсгал шилжүүлэг	89,670,500.02	20,187,450.02
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	77,211,500.02	8,324,500.02
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,459,000.00	11,862,950.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	114,578,047.62	66,792,707.05
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,345,880.62	66,792,707.05
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	113,232,167.00	
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	18,090,300.00	167,570,216.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	23,000,000.00	1,498,000.00
	Дотоод эх үүсвэрээр	23,000,000.00	1,498,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	23,000,000.00	1,498,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(23,000,000.00)	(1,498,000.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(4,909,700.00)	166,072,216.00
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		3,617,535.00
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,617,535.00	14,835.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	389,700,520.28	63,651,297.31	32,686,065.96	486,037,883.55
2	Тайлант үеийн үр дүн			(15,671,532.51)	(15,671,532.51)
3	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	389,700,520.28	63,651,297.31	17,014,533.45	470,366,351.04
4	Тайлант үеийн үр дүн			185,223,620.70	185,223,620.70
5	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	389,700,520.28	63,651,297.31	202,238,154.15	655,589,971.74

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО	1,028,387,600.00	961,594,892.95	66,792,707.05
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ			
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,028,387,600.00	961,594,892.95	66,792,707.05
132001	Орон нутгийн төсвөөс	1,028,387,600.00	961,594,892.95	66,792,707.05
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	300,000.00	400,000.00	(100,000.00)
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	300,000.00	400,000.00	(100,000.00)

1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,028,687,600.00	961,994,892.95	66,692,707.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,028,687,600.00	961,994,892.95	66,692,707.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	998,847,100.00	941,807,442.93	57,039,657.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	789,929,700.00	771,247,988.00	18,681,712.00
210101	Үндсэн цалин	423,782,600.00	416,025,641.00	7,756,959.00
210102	Нэмэгдэл	253,229,100.00	254,900,765.00	(1,671,665.00)
210103	Унаа хоолны хөнгөлөлт	34,204,000.00	40,289,294.00	(6,085,294.00)
210104	Урамшуулал	78,714,000.00	60,032,288.00	18,681,712.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	103,346,900.00	95,481,659.39	7,865,240.61
210201	Тэтгэврийн даатгал	67,075,900.00	65,129,677.75	1,946,222.25
210202	Тэтгэмжийн даатгал	9,067,900.00	7,868,476.55	1,199,423.45
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,533,800.00	3,862,958.45	670,841.55
210204	Ажилгүйдлийн даатгал	4,533,800.00	3,724,109.51	809,690.49
210205	Эрүүл мэндийн даатгал	18,135,500.00	14,896,437.13	3,239,062.87
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,804,000.00	30,426,156.54	377,843.46
210301	Гэрэл, цахилгаан	3,245,000.00	2,604,015.07	640,984.93
210302	Түлш, халаалт	25,579,400.00	25,862,144.00	(282,744.00)
210303	Цэвэр, бохир ус	1,979,600.00	1,959,997.47	19,602.53
2104	Хангамж, бараа материалын зардал	21,788,800.00	15,205,535.00	6,583,265.00
210401	Бичиг хэрэг	2,530,000.00	1,208,300.00	1,321,700.00
210402	Тээвэр, шатахуун	14,250,000.00	10,206,820.00	4,043,180.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,800,000.00	2,556,185.00	243,815.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	58,800.00	36,860.00	21,940.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,150,000.00	1,197,370.00	952,630.00
2105	Нормативт зардал	650,000.00		650,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	650,000.00		650,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,500,000.00	9,493,700.00	8,006,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,000,000.00		8,000,000.00
210602	Тавилга	1,500,000.00	1,498,000.00	2,000.00
210604	Урсгал засвар	8,000,000.00	7,995,700.00	4,300.00
2107	Томилолт, зочны зардал	15,644,200.00	8,870,000.00	6,774,200.00
210702	Дотоод албан томилолт	15,644,200.00	8,870,000.00	6,774,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,915,500.00	10,806,562.00	3,108,938.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,200,000.00	7,550,000.00	2,650,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,800,000.00	1,800,000.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	120,000.00	114,192.00	5,808.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	22,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,650,000.00	1,230,000.00	420,000.00
210807	Газрын төлбөр	90,500.00	90,370.00	130
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,268,000.00	275,842.00	4,992,158.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал			
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,268,000.00	275,842.00	4,992,158.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,840,500.00	20,187,450.02	9,653,049.98
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,840,500.00	20,187,450.02	9,653,049.98
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	5,900,000.00		5,900,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,340,500.00	8,324,500.02	15,999.98
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,600,000.00	11,862,950.00	3,737,050.00
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	1,028,687,600.00	961,994,892.95	66,692,707.05
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		3,617,535.00	(3,617,535.00)

31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		14,835.00	(14,835.00)
----	---	--	-----------	-------------

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	291,256,367.00
21	Урсгал зардал	121,581,451.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,506,280.00
210101	Үндсэн цалин	1,506,280.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,156,720.00
210402	Тээвэр, шатахуун	3,401,540.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,755,180.00
2107	Томилолт, зочны зардал	1,610,000.00
210702	Дотоод албан томилолт	1,610,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	113,308,451.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	109,235,000.00
210902	Сургалт, дадлага бэлтгэлийн зардал	4,073,451.00
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	169,674,916.00
3500	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлого	291,256,367.00
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого	291,256,367.00
	ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО	291,256,367.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 16,328.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 338.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 8,251.8 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 7,738.1 мянган төгрөгийн зөвлөмжийг хүргүүллээ.

Залруулагдаагүй алдаа:

Аудитаар нийт 16,328.2 мянган төгрөгийн зөрчил илэрч, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх хугацаатай зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн актыг хүргүүллээ.

3.1 Төлбөрийн акт

Албан томилолтоор ажилласан албан хаагчдад 338.0 мянган төгрөгийн хоолны мөнгийг давхардуулан олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т (*Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;*), Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2-г (*Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараах зардлаас бүрдэнэ: 2.2.1. унааны зардал; 2.2.2. байрны зардал; 2.2.3. хоолны зардал*) заасныг зөрчсөн ба үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тайлант онд илүү, давхардуулан тооцож олгосон 338,000.00 (гурван зуун гучин найман мянган) төгрөгийн хоолны зардлыг хавсралтад заасан албан хаагч нараар Дундговь аймгийн Төрийн сан банк дахь 100080000955 тоот дансанд 2026 оны 05 дугаар сарын 25-ны дотор нөхөн төлүүлэх;

3.2 Албан шаардлага

Албан томилолтын 90.0 мянган төгрөгийн зардлыг бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний хураамж зардлаас төлсөн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д (*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*), Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-г (*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*), 20.2.3-г (*холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах*) заасныг зөрчсөн ба үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн

3.3 Зөвлөмж

Элэгдлийн зардлаар анхны өртгөө бүрэн нөхсөн, 7,738.1 мянган төгрөгийн цаашид ашиглах боломжтой хөрөнгийг дахин үнэлэх саналаа холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлж, шийдвэрлээгүй. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31.3.2-т (*илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох*), Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам-ын 5.14-т (*үндсэн хөрөнгөнд хамаарах хөдлөх хөрөнгийг худалдах, үнийг шинэчлэн тогтоох зорилгоор санал бэлтгэх, тусгай зөвшөөрөл бүхий этгээдээр хөрөнгийн үнэлгээ хийлгэх*) заасныг зөрчсөн ба иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хагас жилээр зөвлөмж хүргүүлсэн

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 100% хувийг залруулагдаагүй алдаа эзэлж байна. Нийт 16,328.2 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчлөөс 7,738.1 мянган төгрөгийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал, 8,589.9 мянган төгрөгийн санхүүгийн тайлангийн аудитын асуудал байна. Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдах боломжгүй, аудитын дүгнэлтэд нөлөөлөх 8,589.9 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг түвшнээс 3,410.1 мянган төгрөгөөр бага байгаа тул “ӨӨРЧЛӨЛТГҮЙ” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хувь хүний орлогын албан татварын тайланд төгрөгийн цалингийн зардлыг илүү тайлагнасан.	1	8,161.9			1	8,161.9				
Албан томилолтоор ажилласан албан хаагчдад хоолны мөнгийг давхардуулан олгосон	1	338.0	1	338.0						
Албан томилолтын зардлыг бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний хураамж зардлаас төлсөн	1	90.0			1	90.0				
Дүн	3	8,589.9	1	338.0	1	8,251.9				

4.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Элэгдлийн зардлаар анхны өртгөө бүрэн нөхсөн, цаашид ашиглах боломжтой хөрөнгийг дахин үнэлэх саналаа холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлж, шийдвэрлээгүй.	1	7,738.1			1	7,738.1		
Дүн	1	7,738.1			1	7,738.1		